

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	17
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	17
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	18
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	20
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	22
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	24
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН
САНГИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ж.АРИУНБОЛД ТАНАА

2020.03.25 № 06/945
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Боловсролын зээлийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын зээлийн сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Боловсролын зээлийн сангийн санхүүгийн тайланд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Өмнөх онуудад үүссэн 24,129.8 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогч тодорхойгүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй,
- Оюутны хөгжлийн зээлийн 6,398.9 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, оюутны хөгжлийн зээлийн дүн тооцоо нийлсэн актын дүнгээс 1,556.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Дипломын тооллогын ажлын хэсгийн тайлангийн авлагын дүн дипломын дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 3,326.1 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн,
- Үл хөдлөх хөрөнгийн барьцаагүйгээр 6 суралцагчид 369.6 сая төгрөгийн зээл олгосон,
- Өмнөх үеийн үр дүнд бүртгэсэн 7,393.4 сая төгрөгийн эргэж төлөгдөх зээлийн чөлөөлөлтийн дүн анхан шатны баримтаас 2,203.8 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх, ангилал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Боловсролын зээлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг орхигдуулахгүй аккруэл сууриар хөтлөх, анхан шатны баримт бүрдлийг хангах, ажил гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж байх, хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодох, үр дүнг санхүүгийн тайланд тусгаж байх, үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлуулах, өмнөх үеийн үр дүнд бүртгэсэн алдааг залруулах, зардлыг тайлант хугацаанд хүлээн зөвшөөрч байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын зээлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 09-нөөс 2020 оны 3 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Энхжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсролын зээлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр 84 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Боловсролын зээлийн сангийн зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Сургалтын төрийн сан нь 2016 оны 111 дүгээр тогтоолоор Боловсролын зээлийн сан болон өргөжиж төрийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд дотоод болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа оюутан залуучуудад санхүүгийн дэмжлэг үзүүлж, зээл, буцалтгүй тусламж олгох үйлчилгээг зохион байгуулан ажиллаж байна. Сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Боловсролын зээлийн сангийн дүрмээр зохицуулахаар заажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сан нь БСШУСС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг бөгөөд Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлтийг мөрдөн ажиллаж байна.

Боловсролын зээлийн сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Тус сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Боловсролын зээлийн сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 74,956.4 сая төгрөгөөс тооцон 749.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тогтоохдоо материаллаг байдлын хувь хэмжээ, суурийг өөрчлөөгүйгээр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Боловсролын зээлийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,945.4 сая төгрөгөөр буюу 18.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	185,000.9	219,965.2	34,964.3
Мөнгөн хөрөнгө	561.9	105.0	-456.9
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,416.1	1,023.6	-392.5
Авлага	183,019.1	218,835.2	35,816.1
Бараа материал	3.7	1.3	-2.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	173.2	154.3	-18.9
Үндсэн хөрөнгө	173.2	154.3	-18.9
Биет хөрөнгө	50.2	31.3	-18.9
Биет бус хөрөнгө	123.0	123.0	0.0
Нийт хөрөнгийн дүн	185,174.1	220,119.5	34,945.4
Нийт өр төлбөр	9.0	14.1	5.1
Богино хугацаат өр төлбөр	9.0	14.1	5.1
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	185,165.1	220,105.5	34,940.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	185,165.1	220,105.5	34,940.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	185,174.1	220,119.5	34,945.4

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, засгийн газрын хувь оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 19.6 хувь буюу 35,816.1 сая төгрөгөөр өссөн нь оюутны хөгжлийн зээл 25,619.2 сая, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад олгосон зээл 11,400.1 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад авлага 1,203.2 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 220,105.5 сая төгрөг болж 34,940.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд санхүүгийн үр дүн 42,997.3 сая төгрөгөөр нэмэгдэж, өмнөх үеийн үр дүн 8,056.9 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын дүн нь эргэн төлөгдөх зээлийн төлөлт, чөлөөлөлттэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Боловсролын зээлийн сан нь тайлант онд орлогын төлөвлөгөө батлуулаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 20,156.4 сая төгрөгийн төсвийг урсгал зардалд, 3 хөтөлбөрт зориулан 49,800.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд баталжээ.

Тайлант онд улсын төсвөөс 69,681.4 сая төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтөөс 3,512.9 сая, валютын ханшийн зөрүүгийн олз 40.1 сая, бусад орлого 6.6 сая, нийт 73,241.0 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 17,724.0 сая, эргэж төлөгдөх зээлд 47,047.5 сая төгрөгийг зарцуулан, үлдэгдэл 8,925.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардал 64,771.5 сая төгрөг буюу 92.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь урсгал шилжүүлэг 2,420.2 сая, эргэж төлөгдөх цэвэр зээл 2,752.5 сая төгрөг зарцуулаагүй үлдсэн нь голлон нөлөөлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Оны эхэнд нэмэлт санхүүжилтийн дансанд 0.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол зээлийн эргэн төлөлт 52.7 сая, үнэт цаасны хүүгийн орлого 22.7 сая, бусад орлого 3.8 сая нийт 79.2 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс 20.0 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, үлдэгдэл 59.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 51,016.0 сая төгрөгийн 14 алдаа, зөрчил илрүүлснээс 4.8 сая төгрөгийн 1 акт тогтоож, 43,840.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 7,171.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Тайлант оны эцэст урсгал засварын зардлаас батлагдсан төлөвлөгөө хөтөлбөргүйгээр 4.8 сая төгрөгийг сургалтын төлбөрт урьдчилан шилжүүлэн зардалд бүртгэсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "... төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "... ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 4.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

2. Авлага, өглөгийн данс, зорилтот хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой 41,279.6 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Өмнөх онуудад үүссэн 24,129.8 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогч тодорхойгүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй,
- Оюутны хөгжлийн зээлийн 6,398.9 сая төгрөгийг, их дээд сургуулиудаар дамжуулан зорилтот хөтөлбөрт олгосон буцалтгүй тусламж, санхүүжилтийн 2,646.4 сая төгрөгийг, өглөг 9.9 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Оюутны хөгжлийн зээлийн санхүүжилтийн дүн тооцоо нийлсэн актын дүнгээс 1,556.7 сая төгрөгөөр, зорилтот хөтөлбөрийн санхүүжилтийн дүн тооцоо нийлсэн актын дүнгээс 3,114.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Дипломын тооллогын ажлын хэсгийн тайлангийн авлагын дүн хөнгөлөлттэй зээлээр суралцаж төгссөн төгсөгчдийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 3,326.1 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн,
- Хасах дүнтэй 97.3 сая төгрөгийн авлагыг бүртгэсэн байна.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.3-д "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1-д

"анхан шатны баримт бүрдүүлэх", 14.3.2-д "журналд бичих", 14.3.3-д "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг үнэн зөв хөтөлж, авлага, өглөг, тайлант хугацаанд гарсан санхүүжилтийг тооцоо нийлж баталгаажуулах талаар албан шаардлага хүргүүлсэн.

3. Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагын бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн 177 суралцагчдын материалыг түүвэрт хамруулахад 2,554.6 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Засгийн газраас баталсан тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлд багтаагүй мэргэжлээр бакалаврын хөтөлбөрийн 25 суралцагчдад 799,333.52 ам.доллар буюу 2,185.0 сая төгрөгийн /2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн ханшаар 1 ам.долларыг 2,733.52 төгрөгөөр тооцов/ зээл олгосон,
- Үл хөдлөх хөрөнгийн барьцаагүйгээр 6 суралцагчид 135,230.00 ам.доллар буюу 369.6 сая төгрөгийн /2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн ханшаар 1 ам.долларыг 2,733.52 төгрөгөөр тооцов/ зээл олгосон байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах", Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7-д "Гадаад улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа Монгол Улсын иргэнд Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл олгож болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ын 1.3, 1.4, 1.10, 2.4, Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 3.2-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа суралцагчдад олгох зээлийг холбогдох хууль журмын дагуу санхүүжүүлэх, үл хөдлөх хөрөнгийн барьцаагүйгээр зээл олгохгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант хугацаанд түлш, шатахуунтай холбоотой 5.8 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Түлш, шатахууны 3.9 сая төгрөгийн тайлан бэлтгээгүй,
- Шатахуун талон, шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүйгээр бөөн дүнгээр бүртгэсэн,
- Анхан шатны баримтгүйгээр 1053 литр буюу 1.9 сая төгрөгийн шатахууныг зардлаар бүртгэсэн байна.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "... анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, ... баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "... төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахуун зарцуулалтын тооцоо хийх, тайлан бэлтгэх, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

5. Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа суралцагчийн суралцах хугацаа, суралцаж байгаа мэргэжил, сурлагын дүн, төгсөгчдийн гэрээний үүргийн биелэлтэд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- Боловсролын зээлийн сан нь БСШУСС-ын 2019 оны А/392 дугаар тушаалаар 1 жилийн магистрын хөтөлбөрт суралцах суралцагчийн гэрээг 2 жилээр байгуулан 2018-2019 оны сургалтын төлбөр 16,000.00 ам.долларыг хувийн дансанд шилжүүлсэн,
- БШУС-ын 2014 оны А/219 дүгээр тушаалаар 2 жил бакалаврын хөтөлбөрт суралцах суралцагчийн магистрын хөтөлбөрийн сургалтын төлбөрт 29,445.00 ам.долларыг олгосон,
- Бакалаврын хөтөлбөрийн 2, магистрын хөтөлбөрийн 1 суралцагч төгсөөд бүртгүүлсэн гэх боловч дипломоо бүртгүүлээгүй,
- Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа 24 суралцагчийн нэхэмжлэхийн дүн бөөн дүнгээр бичигдсэнийг хянах боломжгүй, сургалтын төлбөрт хамаарагдах зардлууд тодорхойгүйгээс 5 суралцагчид сургалтын төлбөрөөс бусад зардалд 11,077.46 ам.долларыг шилжүүлсэн, суралцаж байгаа суралцагчдын сурлагын дүнд хяналт тавиагүй байна.

Эдгээр зөрчил нь Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 5.2-д "... зээлийн гэрээнд талуудын эрх, үүрэг, зээлийн санхүүжилтийн хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлийг тодорхой тусгана.", 5.4-д "Сургалтын төлбөрийн зээлийн санхүүжилтийг тухайн суралцагчийн суралцаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын дансанд шилжүүлнэ", 5.8-д "... зээлийн гэрээг сунгах, санхүүжилтийг олгох, зогсоох асуудлыг дээд боловсролын сургалтын байгууллагын тодорхойлолт, сурлагын дүнг үндэслэн шийдвэрлэнэ.", Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоол "Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах журам"-ын 1.9-д "... зөвхөн үндсэн ангийн суралцагчид олгоно", 3.3-г "... гэрээг сунгах нөхцөл, суралцагчийн голч дүнд тавих шаардлага, ... гэрээний заалт зөрчигдсөн тохиолдолд талуудын хүлээх хариуцлага, гэрээг цуцлах, санхүүжилтийг зогсоох, энэ тохиолдолд олгосон зээлийг эргэн төлүүлэх нөхцөл зэргийг тодорхой тусгана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын төлөвлөлтийн шатанд зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

6. Өмнөх онд худалдан авсан гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагсад олгох тэтгэлэг зээл, тусламжийн бүртгэлийн программыг ашиглаагүйгээр шинэ программ худалдан авсан, суралцагчдын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлж ажиллаагүй байна.

Энэ зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 6.1-д "... зээл авсан суралцагчдын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлж ажиллана", Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоол "Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах журам"-ын 1.8-д "... харилцан мэдээлэл солилцож, мэдээллийн сан бүрдүүлнэ..." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын төлөвлөлтийн шатанд зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 7,171.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын явцад илэрсэн, дараах асуудлуудад Боловсролын зээлийн сан, БСШУСЯ-ны удирдлагууд анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Тухайлбал:

1. Гадаад орны дээд боловсролын байгууллагад суралцагчдад олгосон ам.долларын зээлийн эргэн төлөлтийг үндэсний мөнгөн тэмдэгтээр эсвэл гадаад валютаар төлөх асуудлыг гэрээнд тодорхой тусгаагүй;

2. Гадаад орны дээд боловсролын байгууллагад суралцагчдын амьжиргааны зардлыг олгох асуудлыг нарийвчлан зохицуулаагүй;

3. Япон улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа “Инженер технологийн дээд боловсрол төсөл”-ийн хүрээнд тухайн мэргэжлээр суралцагчтай байгуулсан гэрээнд зээлийн эргэн төлөлтийн нөхцөл, хугацаа тодорхой бус;

4. Суралцагчдын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, цахимжуулах ажил хангалтгүй;

5. Аудитын төлөвлөлтийн шатанд БСШУСЯ-нд тухайн байгууллага, салбарын хууль эрх зүйн орчинтой холбоотой өгсөн 3 зөвлөмж, 2 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах. Үүнд:

- Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоо, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад сургалтын төлбөрийн зээл олгох хяналтын тоог батлах, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагын магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа суралцагчийн зээлийн хэмжээг батлуулж мөрдөж ажиллах талаар хүргүүлсэн албан шаардлага;
- Багш мэргэжлээр суралцагчдын сургалтын төлбөрийн санхүүжилтийг тодорхой болгох, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагын магистр, докторын хөтөлбөрийн зээлд хамрагдах суралцагчийг сонгон шалгаруулах журмыг баталж мөрдөх, сургалтын зээлийг чөлөөлөх, эргэн төлүүлэх журмыг тодорхой болгох талаар өгсөн зөвлөмжүүд;

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д “... эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно” гэж заасныг зөрчиж гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын эргэн төлөгдөх зээлийг Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын тушаалаар чөлөөлдөг асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Боловсролын зээлийн сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 517 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 90 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнээс Монгол банкаар дамжуулан хийсэн орлогын 12, зарлагын 58, төрийн сангийн дансаар хийсэн 20 гүйлгээ байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 194.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 0.1 сая төгрөгийн 1 акт, 155.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 38.7 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Дэлхийн шилдэг их сургуулиудад суралцагчдад сургалтын төлбөрийг илүү олгосныг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зөрчилд тогтоосон төлбөрийн акт 5.9 хувийн,
- Авлагын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллаагүй, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад үл хөдлөх хөрөнгийн барьцаагүйгээр суралцагчдад зээл олгосон, сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг хувийн дансанд шилжүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлагын хэрэгжилт 62.0 хувийн,
- Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаад төгсөж ирсэн суралцагчдын гэрээний үүргийг хангуулаагүй, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагсдын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж ажиллаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 41.4 хувийн биелэлттэй байна.

Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсролын зээлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсролын зээлийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэлийг Аудитын гэрчилгээний аудитын гол асуудал хэсэгт тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

1. Өмнөх үеийн үр дүнтэй холбоотой 5,549.5 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:
 - БСШУСС-ын 2019 оны А/658 дугаар тушаалаар чөлөөлсөн суралцагчдын эргэж төлөгдөх зээл 2,885.0 сая төгрөг, тайлант хугацаанд төлсөн зээлийн эргэн төлөлт 460.7 сая төгрөгийг өмнөх үеийн үр дүнд бүртгэсэн,
 - Өмнөх үеийн үр дүнд бүртгэсэн 7,393.4 сая төгрөгийн эргэж төлөгдөх зээлийн чөлөөлөлтийн дүн анхан шатны баримтаас 2,203.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Үүнд: 2018 онд 2,238.4 сая төгрөг /дундаж ханш 1ам.доллар=2,464.44 төгрөг/, 2019 онд 34.6 сая төгрөг /дундаж ханш 1ам.доллар=1,266.86 төгрөг/ байна.
2. Эргэж төлөгдөх цэвэр зээлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:
 - БСШУСС-ын 2019 оны А/658 дугаар тушаалаар анхан шатны баримт бүрдэлгүй 6 суралцагчийн 173,230.00 ам.долларын эргэн төлөгдөх зээлийг чөлөөлсөн. /Тухайлбал, төгсөөд дипломоо бүртгүүлээгүй, улсад ажилласан жилээ баталгаажуулаагүй зэрэг/
 - Бакалаврын хөтөлбөрт 2012-2015 онд элссэн 12 суралцагч тэргүүлэх ач холбогдолд багтаагүй мэргэжлээр суралцсан, төгсөөд бүртгүүлээгүй,
 - Гадаадад суралцагчдын хувийн хэрэг, суралцагчдыг чөлөөлсөн тушаал зэрэг баримтуудыг ам.доллароор бүртгэн төгрөгөөр илэрхийлээгүй, гадаад валютын ханшийн үр нөлөөг тооцоогүй байна.

Эдгээр зөрчил нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д “суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их хурал тогтооно”, Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-ын 1.3, 1.4, 3.3, 4.1, Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ын 5.2,

5.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага ажил, гүйлгээгээ үндэсний мөнгөн тэмдэгтээр бүртгэж, тайлагнана” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан, гадаад валютын ханшийн үр нөлөө буруу илэрхийлэгдэх, зээлийн үлдэгдлийг буруу тайлагнах, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Өмнөх үеийн үр дүнд алдаатай бүртгэсэн ажил гүйлгээг залруулах, зээлийн чөлөөлөлт, эргэн төлөлтийг тайлант үед хүлээн зөвшөөрч байх, анхан шатны баримт бүрдэлгүйгээр чөлөөлсөн суралцагчдын зээлийн чөлөөлөлтийг хүлээн зөвшөөрөхгүйгээр залруулах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, суралцагчдын гэрээний үүргийг хангуулах, ажил гүйлгээ, анхан шатны баримтыг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тендерийн баталгаагүйгээр 45.0 сая төгрөгийн гадаад зээлийн программ худалдан авсан, анхан шатны баримт бүрдэлгүй 27.8 сая төгрөгийн, шууд зардалд 14.6 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Эдгээр зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Захиалагч энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, ... худалдан авах тендерт оролцогчоос тендерийн баталгаа ирүүлэхийг шаардана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2 Эрсдэл:

Бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэлийн баталгаагүй байх, зардал хүлээн зөвшөөрөгдөхгүй байх, орлого үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Босго үнээс дээш өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа тендерт оролцогчоос тендерийн баталгаа гаргуулах, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах, ажил гүйлгээг шууд зардалд бүртгэхгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудыг мөрдөж ажиллах;

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Үнэт цаастай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Хугацаа сунгуулаагүй 752.7 сая төгрөгийн үнэт цаасыг санхүүгийн тайланд бүртгэсэн, үнэт цаасны хүүгийн авлага 1.7 сая төгрөгийг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл:

Үнэт цаас баталгаажихгүй байх, хүүгийн авлага төлөгдөхгүй байх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Үнэт цаасны хугацааг сунгуулах, хүүгийн авлагыг залруулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1 дэх заалтуудыг мөрдөж ажиллах;

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. **Балансын данстай холбоотой асуудал**

4.1 Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 472.5 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Төрийн сангийн харилцах дансны 460.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг мөнгөн гүйлгээний журналд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5-д "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.2 Эрсдэл:

Мөнгөн хөрөнгө, авлагын үлдэгдэл, мөнгөн гүйлгээний тайлан буруу илэрхийлэгдэх, зээлийн эргэн төлөлт баталгаажихгүй байх.

4.3 Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулах, ажил гүйлгээг орхигдуулахгүй бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж ажиллах;

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5. **Балансын данстай холбоотой асуудал**

5.1 Илрүүлэлт:

Бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой 155.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Бараа материал, үндсэн хөрөнгийн 155.7 сая төгрөгийн тайлан бэлтгээгүй, тооллого хийж тооцоо бодоогүй, үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй,
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 15.8 сая төгрөгийн 10 ширхэг компьютер биетээр оршихгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т “1/ үндсэн хөрөнгө, ... тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/, 2/ ... бараа, ... тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.2 Эрсдэл:

Хөрөнгө үрэгдэх, хөрөнгийн үлдэгдлийн дүн буруу илэрхийлэгдэх.

5.3 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллогыг хийх, тооцоо бодож үр дүнг санхүүгийн тайланд тусгах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж ажиллах;

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

6 **Балансын данстай холбоотой асуудал**

6.1 Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөтэй холбоотой 45.0 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа суралцагчид олгох зээлийн бүртгэлийн программыг 45.0 сая төгрөгөөр худалдан авч шууд зардалд бүртгэсэн,
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 140.3 сая төгрөгийн 3 программ бүртгэлтэйгээс ашиглалтын хугацааг -1 жилээр бүртгэн тайлант хугацаанд хорогдуулгыг бүртгээгүй,
- Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нь тайлант хугацаануудын 50.0 мянга орчим харилцагчийн мэдээлэлтэй уялдаагүй, мэдээллийг боловсруулах, эдийн засгийн орчинд ажиллах бусад программтай мэдээлэл солилцох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, УСНББОУС 31 “Биет бус хөрөнгө”-ийн “... ашиглалтын хугацаа /87-95/, тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө /96-105/, тодорхойгүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө /106-109”-д заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

6.2 Эрсдэл:

Хөрөнгө үрэгдэх, үнэгүйдэх, тайлант үеийн зардал хүлээн зөвшөөрөгдөхгүй байх, санхүүгийн тайлан, мэдээ зөрүүтэй илэрхийлэгдэх.

6.3 Өгсөн зөвлөмж:

Гадаад зээлийн бүртгэлийн программыг биет бус хөрөнгөөр бүртгэх, ашиглалтын хугацаа, хорогдуулгыг үнэн зөв тооцох, санхүүгийн тайлан, мэдээг харилцагчийн болон бусад мэдээлэлтэй уялдуулан боловсруулж байх;

6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

7 Батлагдсан төсөвтэй холбоотой асуудал

7.1 Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн дансанд зээлийн эргэн төлөлтийн 52.7 сая, хүүгийн орлого 22.7 сая, нийт 75.4 сая төгрөг төвлөрснөөс, орлогын төлөвлөгөө батлуулаагүйгээр 20.0 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-д “Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ”, 47 дугаар зүйлийн 47.1.5-д “төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

7.2 Эрсдэл:

Төсвөөс үргүй зардал гарах, орлогыг хяналтгүйгээр зарцуулах.

7.3 Өгсөн зөвлөмж:

Орлогын төлөвлөгөө батлуулах, зээлийн эргэн төлөлтийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4, 47 дугаар зүйлийн 47.1.5 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах;

7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

8 Тайлагналтай холбоотой асуудал

8.1 Илрүүлэлт:

ХХОАТ-ын тайланд цалин, хөдөлмөрийн хөлс 28.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, ХХОАТ-ын өглөг 2.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

8.2 Эрсдэл:

ХХОАТ-ыг буруу илэрхийлэгдэх.

8.3 Өгсөн зөвлөмж:

Цалингийн дүнг ХХОАТ-ын тайланд бүрэн тусгах, татварыг холбогдох хуулийн дагуу зөв ногдуулж, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, ХХОАТ-ын тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах;

8.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

